

## МЭРГЭЖЛИЙН ГАЖУУДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ NOTION ABOUT PROFESSIONAL DEFORMATIONS



### **Б.МӨНХБААТАР**

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн багш, ахмад

**Товч агуулга:** Мэргэжлийн болон хувь хүний гажуудлын талаар судлаачдын байр суурийг харьцуулан тайлбарласан болно.

**Түлхүүр үг:** Мэргэжлийн гажуудал, хувь хүний гажуудал,

**Abstract:** The position of experts on professional and personal distortions is compared.

**Key words:** professional deformation, person distortion

Төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлийн үйл явцын хүрээнд байгууллагын стратеги зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд тухайн цаг үеийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэдлэг, чадвартай хүний нөөц буюу боловсон хүчнийг сонгон ажиллуулах нь хувийн хэвшил болон төрийн үйлчилгээний чанар, үр ашигтай шууд хамааралтай байдаг.

Өөрөөр хэлбэл энэ нь өнөөгийн нийгэмд байгууллагыг тодорхойлогч гол хүчин зүйлийн нэг бол мэдлэг, ур чадвартай мэргэжлийн гэж тодотгож болох хүний нөөцтэй байх явдал бөгөөд энэ нь байгууллагын хөгжлийн үндэс нь болж байдаг.

Гэвч мэргэжлийн гэх энэхүү тодотголыг сэтгэл судлалын шинжлэх ухааны гол зарчмуудын үүднээс авч үзвэл оюун ухаан, ухамсар, үйл хөдлөл ба хувь бие хүний цогц нэгдлийн талаар тодорхойлох болдог. Тэгвэл хүний ажил мэргэжил хүний хувь хүнийг үүсгэж бүрдүүлдэг хүчин зүйлүүдийн нэг хэдий ч нөгөөтэйгүүр гажуудуулж эвдэлж өөрчилж байдаг шинжтэй гэдгийг санах нь зүй юм.

Мэргэжлийн болон хувь хүний гажуудлыг орчин үед судлаачид 2 талаас нь судалж үздэг. Энэ нь ажил хөдөлмөр эрхлэх үеийн үл дасан зохицох асуудал, нөгөө талаас мэргэжлийн гажуудал нь ажил мэргэжилдээ

дасах нууц механизм гэж үздэг.<sup>1</sup> Анх 1915 онд “Америкийн социологийн сэтгүүл” дээр «professional deformation» гэдэг нэр томъёог ашиглаж байсан бөгөөд нэр томъёоллыг анх америкийн социологч Х.Ландерок<sup>2</sup> оруулж ирсэн гэж үздэг байна.

Оросын холбооны улсын шинжлэх ухааны салбар болон нийгмийн агуулгад энэхүү нэр томъёог анх 1921 онд америкийн орос гаралтай социологч Питирим Сорокин оруулж ирсэн бөгөөд тэрээр уг нэр томъёог тайлбарлахдаа “... мэргэжлийн гажуудал бол мэргэжил хөдөлмөрийн үйл ажиллагааны хувь хүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг мэргэжлийн гажуудал гэж нэрлэнэ...”<sup>3</sup> хэмээн тодорхойлсон байдаг.

Хууль сахиулах салбарт ажиллах боловсон хүчний хувьд эзэмшсэн мэргэжил нь төр, нийгмийн өмнө өндөр үүрэг хариуцлагыг хүлээлгэдэг онцлогтой. Өөрөөр хэлбэл тухайн мэргэжлийг эзэмшсэнээр бие физиологийн болон сэтгэл зүйн хувьд өндөр ачаалал дунд ажиллах шаардлага үүсэхээс гадна тухайн мэргэжил нь тодорхой эрсдлийг дагуулдаг, харин үүнээс болж үүсч байгаа сэтгэл зүйн холбогдолтой асуудлын нэг нь мэргэжлийн болон хувь хүний гажуудал юм.

С.П.Безносков “... Мэргэжлийн хувь хүний гажуудал-үндсэн утгаараа бол ажил хөдөлмөрийн объектив чанарын нөлөөнөөс болж хөдөлмөрийн субъектын хувь хүний өөрчлөлт юм. Харин тусгай утгаараа бол ажил мэргэжлийн нөлөөнөөс бол хувь хүний үнэ цэнийн чиг хандлага, үзэл бодол, ес суртахуун, ухамсар, бодол санааны өөрчлөлт цаашдаа хүний сэтгэц бүхэлдээ өөрчлөгдөхийг мэргэжлийн хувь хүний гажуудал гэнэ...”<sup>4</sup> хэмээн тодорхойлсон байдаг.

Харин К.Р.Такасаева хууль сахиулах үйл ажиллагаа тэр дундаа ажилтан алба хаагчийн мэргэжлийн болон хувь хүний гажуудлыг

<sup>1</sup> . Вигдорчик Н.А. Компенсаторное профессиональное приспособление // История советской психологии труда. Тексты (20—30-е годы XX века) / Под. редакцией В.П. Зинченко, В.М. Мунипова, О.Г. Носковой. — Москва: Издательство Московского университета, 1983. — С. 213—222.

<sup>2</sup> Дружилов С.А. Профессиональные деформации и деструкции: феноменология и подходы к изучению // Международный журнал прикладных и фундаментальных исследований. — 2013. - № 11. — С. 137-140

<sup>3</sup> Шишкова Г. В. Социологические аспекты детерминант профессиональных деформаций // Вестник Уральского государственного университета путей сообщения. — 2014. — № 1 (21). — С. 116—122.

<sup>4</sup> Безносков С.П. Профессиональная деформация личности. — Санкт-Петербург: Речь, 2004. — 272 с.

цагдаагийн ажилтны хууль ёс зүйг хангах үйл ажиллагааг явуулах хувь хүн нь бүрэн гүйцэд боловсроогүйгээс үүдэн гардаг хэмээн үзсэн байдаг.<sup>5</sup>

А.В.Буданов өөрийн судалгаан дээр үндэслэн хууль сахиулах ажилтны мэргэжлийн болон хувь хүний гажуудал нь мэргэжлийн ёс зүйн, оюун ухааны, сэтгэл хөдлөлийн хэсгүүдэд ихэвчлэн өөрчлөлт оруулдаг гэж үзсэн байдаг. *Мэргэжлийн ёс зүйн тал* нь тухайн ажилтан алба хаагч ажил үүргээ хэрэгжүүлэхдээ иргэний болон ёс зүйн үүргээ умартах, ажил албандаа хамаагүй, хайхрамжгүй мэт хандах, өөрийн ажил үүргээ хувийн ашиг сонирхолдоо ашиглах хэрэгсэл мэтээр үзэж төсөөлөх. *Оюун ухааны өөрчлөлт* нь мэргэжлийн буюу ажил үүргийн холбогдолтой асуудлыг шийдэх, шийдвэр гаргалт нь муудаж, асуудалд хандах хандлага нь уян хатан бус болж, ажил мэргэжилдээ шинэ юм сурч ажлын амжилт гаргахгүй болох юм. *Сэтгэл хөдлөлийн тал* дээр өөрчлөлт нь ажилтан алба хаагчдын сэтгэл хөдлөл тогтворгүй болох өөрийгөө хянах хяналтаа алдах, хамт олонтойгоо түрэмгий харьцах мөн муудалцах нь ихсэх зэргээр илэрдэг, зарим тохиолдолд хурдан ядарах байдал нь сэтгэл гутралаар илрэх тохиолдол бий.

С.Е.Борисова мэргэжлийн хувь хүний гажуудлыг “...ажил мэргэжлийн болон өөр багц шалтгаануудаас үүссэн мэргэжилтний хувь хүний тусгай өөрчлөлт юм.” хэмээн тодорхойлсон бөгөөд /ажил мэргэжлээ явуулсан хугацаа туршлага; хувь хүний сэтгэл зүйн онцлог тухайн ажил нийцэхгүй байх; ажлын онцлог болон хувь хүний онцлогийн нөлөөлөл/ гэсэн багц шалтгаануудыг тодорхойлсон байдаг. Мөн тэрээр өөрийн судалгаандаа мэргэжлийн хувь хүний гажуудал нь хувь хүнд үргэлж сөрөг нөлөөтэй байдаггүй гэж дүгнэсэн байдаг байна.

Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоо<sup>6</sup> сүүлийн жилүүдэд буурахгүй, түүнчлэн үйлдэгдэж байгаа шинж чанар нь илүүтэй нийгмийг цочроосон үйлдлүүд бий болсоор байна. Энэ нь хууль сахиулах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хувьд олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад эрчимтэй чиглэгдэж байгаа хэдий ч байгууллагын боловсон хүчин тэдгээрийн мэргэжлийн онцлог, тэдэн дунд үүсээд байгаа мэргэжлээс халшрах хам шинж, мэргэжлийн гажуудалтай холбоотой

<sup>5</sup> Такасаева К.Р. Морально-психологические факторы профессиональной деформации личности сотрудника ОВД: дис. ... канд. псих. наук. - Москва, 2001. – 234 с.

<sup>6</sup> [http://www.1212.mn/stat.aspx?LIST\\_ID=976\\_L23](http://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L23)

асуудлыг судлах хэрэгцээ шаардлага байсаар байгаагийн нотолгоо юм.

Иймд цаашид зарим төрлийн буюу үйл ажиллагааны, мэргэжлийн үйл ажиллагаа нь дахь хүний сэтгэцийн, системчилсэн үйл ажиллагааны зарчмын онолууд дээр суурилсан мэргэжилтний загварыг сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс боловсруулан, цаашид судалгаа шинжилгээний бааз суурь дээр түшиглэн элсэгчдийг сонгон шалгаруулах, цаашлаад мэргэжилтнийг бэлтгэхэд анхаарах асуудлуудыг томъёолох нь зүйтэй юм.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Вигдорчик Н.А. Компенсаторное профессиональное приспособление // История советской психологии труда. Тексты (20—30-е годы XX века) / Под. редакцией В.П. Зинченко, В.М. Мунипова, О.Г. Носковой. — Москва: Издательство Московского университета, 1983.
2. Дружилов С.А. Профессиональные деформации и деструкции: феноменология и подходы к изучению // Международный журнал прикладных и фундаментальных исследований. – 2013. - № 11.
3. Шишкова Г. В. Социологические аспекты детерминант профессиональных деформаций // Вестник Уральского государственного университета путей сообщения. — 2014. — № 1 (21).
4. Безносков С.П. Профессиональная деформация личности. – Санкт-Петербург: Речь, 2004.
5. Такасаева К.Р. Морально-психологические факторы профессиональной деформации личности сотрудника ОВД: дис. ... канд. псих. наук. - Москва, 2001.